



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

**Нийгмийн дэд бүтцэд хамаарах
хотын стандартыг батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийгмийн дэд бүтэц бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1101B:2022 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1102B:2022 “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1103B:2022 “Эрүүл мэндийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

1.4. UCS1104B:2022 “Төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100060